

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 09

## **Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.**

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнд 2025 жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, зорилтыг хүрэх түвшинтэй нь харьцуулан, хэрэгжилтийн түвшинг тогтоох, үр дүнг үнэлэх, дүгнэлт, зөвлөмж гаргах, яамны удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

## **Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй.**

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гарсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн шийдвэр, зүйл, заалтыг хяналтад авч, яамны нэгжүүдийн дүнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар ирүүлсэн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

## **Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн.**

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг дүнд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үнэлж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим системд байршуулсан. Хяналтад авсан нийт 293 шийдвэрийн 665 зүйл, заалтыг салбар чиглэлээр ангилж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ба хэрэгжилтийг **82.59** хувийн биелэлттэй гэж дүгнэв.

Нийт 293 шийдвэрийн 665 зүйл, заалтаас 34 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй хэрэгжилтийг дүгнэсэн, 403 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн”, 180 зүйл, заалт “хэрэгжих шатанд”, “хэрэгжээгүй” 10 , хэрэгжих боломжгүй 28 зүйл, заалт гэж дүгнэсэн.

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**  
/Хууль тогтоомжийн төрлөөр/

**Хүснэгт-1**

	Нийт	МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж	ҮАБЗ-ийн хуралдааны	Засгийн газрын Хэрэг
Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	293	5	26	26	4	116	95	8	11	2	-	-
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	665	8	76	90	4	157	238	75	11	6	-	-
<b>Хэрэгжсэн</b>	<b>403</b>	<b>5</b>	<b>37</b>	<b>34</b>	<b>3</b>	<b>105</b>	<b>162</b>	<b>48</b>	<b>4</b>	<b>5</b>	-	-
Хэрэгжих шатанд	Ахиц гарсан - 50%	92	-	12	22	-	18	19	15	6	-	-
	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	50	-	7	5	-	12	23	3	-	-	-
	Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай - 50%	48	1	8	14	1	4	14	6	-	-	-
Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас - 0%	9	-	2	2	-	-	4	-	1	-	-
	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	1	1	-	-	-	-	-	-	-	-	-
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	34	1	4	4	-	16	6	3	-	-	-	-
Хэрэгжих боломжгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	2	-	-	-	-	2	-	-	-	-	-
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	23	-	6	9	-	7	-	-	1	-	-
	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	2	-	-	-	-	2	-	-	-	-	-
	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Хэмжигдэхүйц биш	1	-	-	-	-	-	1	-	-	-	-
<b>Биелэлтийн дундаж</b>	<b>82.59</b>	<b>78.57%</b>	<b>76.52%</b>	<b>70.78%</b>	<b>87.5%</b>	<b>87.77%</b>	<b>85.59%</b>	<b>83.33%</b>	<b>63.64%</b>	<b>100%</b>	-	-

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг төрлөөр нь авч үзвэл:

- МУ-ын 5 хуулийн 26 заалтын хэрэгжилт 78.57%
- УИХ-ын 26 тогтоолын 76 заалтын хэрэгжилт 76.52%

- УИХ-ын байнгын хорооны 26 тогтоолын 90 заалтын хэрэгжилт 70.78%
- Ерөнхийлөгчийн 4 зарлигийн 4 заалтын хэрэгжилт 87.5%
- Засгийн газрын 116 тогтоолын 157 заалтын хэрэгжилт 87.77%;
- Засгийн газрын хуралдааны 95 тэмдэглэлийн 238 заалтын хэрэгжилт 85.59%;
- Засгийн газрын 8 албан даалгаврын 75 заалтын хэрэгжилт 83.33%
- Ерөнхий сайдын 11 захирамж 11 заалтын хэрэгжилт 63.64%
- ҮАБЗ-ийн 2 зөвлөмжийн 6 заалтын хэрэгжилт 100%

### **Дөрөв. Дүгнэлт.**

1. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан 293 шийдвэрийн 665 зүйл, заалтын хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар **82.59** хувийн биелэлттэйгээр дүгнэлээ.
2. Нийт 293 шийдвэрийн 665 зүйл, заалтаас 34 зүйл, заалтад үнэлгээ өгөөгүй хэрэгжилтийг дүгнэсэн, 403 зүйл, заалт “бүрэн хэрэгжсэн”, 180 зүйл, заалт “хэрэгжих шатанд”, “хэрэгжээгүй” 10 , хэрэгжих боломжгүй 28 зүйл, заалт гэж дүгнэсэн
3. Зарим хэрэгжилт нь шийдвэр, зүйл заалттай тохироогүй хамааралгүй биелэлт гаргасан байна.
4. Хяналтад авагдсан ЗГ-ын хуралдааны тэмдэглэлүүдийн зүйл заалтын утга агуулга тодорхой бус хэрэгжилт гаргахад хүндрэлтэй байна.
5. Стратегийн ордуудын асуудлаар гарсан хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.
6. Хэрэгжилт гаргах боломжгүй гэж ирүүлсэн заалтуудын агуулга тодорхой бус байгаа тул зүйл заалтыг системд тодорхой оруулах
7. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын эрхлэх асуудлаар батлагдсан хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэж байгаа боловч хэрэгжилтийг тайлагнахдаа ажлын гол үр дүнг товч тодорхой (тухайн зорилт, арга хэмжээ, заалтын хүрсэн үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаан), баримт нотолгоонд суурилсан байдлаар тайлагнах шаардлагатай байна.
8. Хэрэгжилт гаргах, зүйл заалт тус бүрээр нарийн тодорхой эзэнжүүлдэггүй. Зарим арга хэмжээ хариуцах тодорхой эзэнгүй байна.

### **Тав. Зөвлөмж.**

1. “Хэрэгжилт удааширсан” буюу “Хэрэгжээгүй” дүгнэгдсэн хэрэгжилтийн явц удаашралтай байгаа ажлуудыг хариуцсан газрууд эрчимжүүлэх, тодорхой арга хэмжээг авах.
2. Хариуцсан ажилтан төрийн албан хаагчид, төрийн өмчит газруудад хариуцлага тооцох, “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хариуцлага тооцох саналыг эрх бүхий албан тушаалтан уламжлах,

Жич: Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хийсэн үнэлгээний тайлан, нэгтгэлийг хавсаргав.

Хянасан:

ХШҮДАГ-ын даргын үүргийг  
түр орлон гүйцэтгэгч

Ц.Өнөрнасан

Үнэлгээ хийж, танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах шинжээч

Д.Батнайрамдал